

Зөв дүгнэлт хийж , бусдыг шүүхгүй байцгаая

Далын Ахлагч Григорий А.Щвицер

Зөв дүгнэлт хийх нь зөвхөн хүмүүсийг ойлгоход төдийгүй бас биднийг Тэнгэрлэг Эцэгтээ ойртох эсвэл Түүнээс холдоход хүргэж болох шийдвэр гаргахад хэрэгтэй юм.

Олон янзын нөхцөл байдал нь биднийг дүгнэлт хийхэд хүндхэн байдалд оруулдаг дэлхийд бид аж төрж байна. Гэсэн ч Аврагч бусдыг “бүү шүү”¹ гэсэн зарлигийг бидэнд өгсөн юм. Хууран мэхлэлт, бусармаг явдлаар дүүрэн дэлхийд бид хэрхэн бусдыг “шүүхгүй” байж, зөв дүгнэлт хийж болох вэ? Найз нөхдөө сонгох, мөнхийн ханиа олох, гэр бүлээ тэтгэж, Их Эзэнд үйлчлэх боломжтой ажил сонгох гээд бид амьдралдаа шийдвэрлэгч сонголт хийхдээ зөв шүүж, зөвөөр тунгаан бодох хэрэгтэй. Аврагч бидэнд бусдыг бүү шүү гэсний хамт хамгийн зөв шийдвэр гаргахыг биднээс хүсэн хүлээдэг билээ.

Бид хүмүүсийн талаар олонтаа яаран дүгнэлт хийдгээс, бидний харилцаа өөрчлөгдөж болно. Бид заримдаа өнгөцхөн мэдээлэл, цаад учрыг нь олохгүйгээр буруу дүгнэлт хийдэг.

Есүс Бетанд ах Лазартайгаа амьдарч байсан Мариа, Марта нарын гэрт айлчлан очсон тухай түүхийг олон удаа дурсан ярьсан байдаг. Их Эзэнийг уриалгахан хүлээн авч, Тэр энд амарч, зөв шударга гэр бүлийнхнээр хүрээлүүлэн баясдаг нэг газар байв. Түүнийг нэг удаа тэнд очих үед Марта хоол хийгээд завгүй гүйж, харин Мариа Их Эзэний хөлд суугаад, үгийг нь сонсож байлаа.

“Марта үйлчлэх ажилдаа түүртсэн тул Есүс уруу ирж, Эзэн, дүү минь үйлчлэх ажилд намайг ганцаар орхисныг Та анзаарахгүй байна уу? Надад тусал гэж түүнд хэлээч гэв.

“Харин Эзэн, Марта, Марта чи мөн ч их зүйлд санаа тавьж, зовох юм даа:

“Үнэндээ ганцхан юм л хэрэгтэй. Мариа өөрөөс нь зайлуулагдашгүй сайныгаа л сонгон авчээ гэсэн аж.”²

Энэ түүхийг ашиглан ням гарагийн олон хичээлийг заасаар ирсэн юм. Уг түүх Мартаг сулхан итгэлтэй байсан мэтээр харагдуулж болох юм. Гэвч энэ гайхамшигт эмэгтэйн ойлголт хэчнээн гүнзгий, гэрчлэл нь хэчнээн бат бөх байсныг харж болох өөр нэг түүх бий. Тэдний ах Лазарыг нас барахад Есүс түүнийг амилуулахаар ирэх үед энэ явдал болжээ. Түүнийг ирж явна гэдгийг “сонсонгуут” Марта шууд Есүс дээр ирэв. Тэр Есүстэй уулзангуутаа “Бурханаас юу ч гуйсан, Бурхан [надад] өгнө” гэдгийг би “мэдэж байна” гэжээ.

Дараа нь Христ түүнтэй амилуулалтын тухай агуу сургаалыг хуваалцаж,

“Би бол амилалт ба амь мөн. Надад итгэдэг хүн үхэвч амьдарна.

“Амьд бөгөөд Надад итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй. Чи үүнд итгэж байна уу?” гэж асуусан юм.

Тэр эмэгтэй бат бөх, гал цогтой гэрчлэлээр: “Тийм ээ, Эзэн. Та бол Бурханы Хүү болох Христ, ертөнцөд ирэх Нэгэн мөн гэдэгт би итгэсэн”³ гэж хариулав.

Сүнсний төлөө биш харин тулга тойрсон юмст илүү анхаарал тавьдаг хүн гэж Мартаг хэчнээн удаа буруу ойлгосон бол? Гэсэн ч ах нь нас барсан зовлонт үед түүний харуулсан гэрчлэл ойлголт, итгэлийнх нь гүн гүнзгийг тод харуулсан юм.

Сүмийн олон эгч нар эхний түүхийг сонсоод, тэд өөрсдийгөө Мариа, Марта хоёрын алинтай нь илүү адил байгааг боддог. Гэвч тухайн хүний талаар цогц мэдлэгтэй байж, зөв тунгаан бодсоноор үнэн мөнөөр нь харж чадна. Бид Мартагийн тухай илүү ихийг мэдэх тусам тэр үнэхээр Аврагчийн зорилго, Түүний үхэл ба амийг хянагч бурханлиг хүчний талаар бат бөх, тууштай гэрчлэлтэй, туйлын сүнслэг хүн байсныг мэдэж болно. Мартагийн тухай буруу ойлголт энэхүү гайхамшигт эмэгтэйн жинхэнэ мөн чанарыг мэдэхгүй өнгөрөхөд биднийг хүргэж мэднэ.

Би залуухан эмч байхдаа яаран дүгнэлт хийхээс нэг сүрхий сургамж авч билээ. Намайг түргэн тусламжийн төвд шөнийн ээлжинд гараад байтал нэгэн залуу хүнд өвчтэй эхнэртэйгээ хүрч ирэв. Хувцаслалт, ариун цэвэр нь тааруухныг хараад тэд ядруухан амьдралтайг нь хэлж болохоор байлаа. Тэр залуугийн үс ургаж өрвийсөн, угаагаагүй нэлээд удсан бололтой бохир хувцастай байв, Хүнд амьдралынх нь ул мөр нүүрэн дээр нь бичээстэй байлаа.

Би эхнэрт нь үзлэг хийсний дараа, нөхөрт нь өвчин болон эмчилгээний талаар тайлбарлахаар суув. Тэр залуу надаас эхнэрээ гэсэн халамж, хайрын өнгөөр: “Эмч ээ, миний хайрт эхнэр зүгээр болох болов уу?” гэж асуухад, түүний нүдэнд хайрын гал дүүрэн байв. Тэр үед Сүнс надад тэр бол Бурханы хүүхэд гэж гэрчлэхийг би мэдэрч, Аврагчийн төрхийг нүднээс нь харсан юм. Үнэхээр бусдын төлөө хайраа харуулсан түүнийг би буруу ойлгосон байлаа. Энэ сургамж надад үүрд үлдсэн юм.

Зөв дүгнэлт зөвхөн хүмүүсийг ойлгоход хэрэгтэй төдийгүй, биднийг Тэнгэрлэг Эцэг уруу хөтлөх эсвэл Түүнээс холдуулах шийдвэртэй тулгарах үед хэрэгтэй байдаг. Амьдралаа эргэн харахад, буруу дүгнэлтийн уршгаар амьдралд минь гарах ялимгүй өөрчлөлт бүр намайг Их Эзэний талд байхаас холдуулж болохыг би ойлгосон юм. Эхнэр бид хоёр сурч байхдаа гэр бүл болж, сайн мэдээний бүх зүйлст идэвхтэй байж, хомсхон орлоготой байсан ч аравны нэгээ бүрэн төлж, хэцүүхэн үедээ ч дуудлага хүлээн авч байсан маань золиослолын талаар илүү ихийг сурч мэдэхэд тусалсан юм. Жинхэнэ сүнслэг шийдвэрийн оронд дэлхийн үзэл бодлоор хандсанаас хүн амьдралдаа олон адислалыг алддаг.

Зөв дүгнэлт хийж чаддаг хүмүүст олон чухал шинж чанар байдаг. Чухал шийдвэр гаргахдаа зөв дүгнэлт хийх дөрвөн удирдамжийг би бүхэнтэй хуваалцъя.

Нэгдүгээрт: хувийн жишгээ Есүс Христийн сайн мэдээтэй нийцүүл. Есүс Христийн сайн мэдээг гол зөвлөгчөө болгохгүйгээр хэн ч зөв дүгнэлт хийж чадахгүй. Хүмүүсийг аз жаргал, амжилт ололтод хүргэсэн олон баримт сайн мэдээнд байдаг. Дэлхийн ойлголтоор хүн зөвхөн өөрөө л хувийн жишгээ тогтоодог. Тиймээс бид “шинэ ёс суртахуун” гэж ярихыг байнга сонсдог. Энэ бол хуурамч үг! Ёс

суртахууны жишиг нь мөнхийн бөгөөд өөрчлөгдөггүй юм. Бид ёс суртахууны жишгийн тухай шинэ үзэл баримтлалыг эрж хайх хэрэггүй. Эдгээрээс залуучуудад зориулсан жишгүүд “Залуучуудын бат бөх байдлын төлөө” товхимолд байгаа. Эдгээр жишиг нь Есүс Христийн сайн мэдээтэй маш нягт уялдсан бөгөөд бид насанд хүрсэн хойноо ч дагах хэрэгтэй жишгүүд юм. Энэ товхимолд насанд хүрсэн бидэнд ч суралцаж, амьдралдаа хэрэгжүүлэх сайн зүйл байгаа нь эргэлзээгүй.

Хоёрдугаарт: амьд бошиглогчдын захиасыг сонс. Бошиглогчдоос олон жилийн турш бидэнд өгч байгаа зөвлөмжүүдийг баримтлан, эрсдэлтэй наймаа, хэрэглээний зээлээс зайлсхийж, үндэслэл сайтай төсөв боловсруулан хэрэглэвэл, санхүүгийн талаар бүтэлгүйтэх шийдвэр гаргахаас хэчнээн удаа зайлсхийж чадахсан бол? Хэчнээн олон гэр бүл порнографын донтолт, зүрх сэтгэлийн эмзэглэлд хөтлөх мэдээллийн есөн шидийн хэрэгслээс зайлсхийж, салж сарнихгүй байсан бол? Ерөнхий чуулган болон Лиахона сэтгүүлийн дугаар бүр бошиглогчдын зөвлөмжийг агуулдаг. Эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр зөв шийдвэр гаргах болно. Бид тэдгээрийг үл тоомсорловол буруу шийдвэр гаргах эрсдэлтэй юм.

Гуравдугаарт: Ариун Сүнснийг сонсохоор гэгээлэг бай. Баптисм хүртсэний дараа бидэнд Ариун Сүнсний бэлэг өгдөг ч амьдралдаа хамгийн чухал шийдвэр гаргахад Тэр туслах болно гэдгийг бид мартан, энэ бэлгийг ихэвчлэн анзааралгүй өнгөрөөдөг. Амьдралдаа хэцүү шийдвэр гаргах хэрэгтэй болно гэдгийг Их Эзэн мэдээд энэ бэлгийг бидэнд өгсөн билээ. Энэ дуу хоолойг сонсох нь зөв дүгнэлт хийхэд амин чухал юм. Бид чимээгүй, нам гүм орчинд тунгаан бодох цаг гаргах юм бол, Ариун Сүнсний намуун, зөөлөн дуу хоолойг сонсох бололж бүрдэх болно. Бид гадаад орчиндоо бас дотоод сэтгэлдээ энэхүү амар амгалан бий болгох ёстой. Энэ нь дэлхийн хөгжмийг, эсвэл мэдээллийн бусад хэрэгслийг унтраахаас гадна, дотоод сэтгэлийн гүн дэх нүглийн дохиог хорино гэсэн үг юм. Энэ нь Сүнстэй харилцах харилцааг нээж өгнө. Энэ харилцаа туйлын чухал юм.

“Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би өөрийн амгаланг та нарт өгнө. Ертөнцийн өдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай”⁴ гэж Христ хэлсэн билээ. Ариун Сүнснийг сонссоноор ирдэг амар амгалан амьдралдаа буруу шийдвэр гаргах айдсыг зайлуулдаг.

Дөрөвдүгээрт: зарлигуудыг сахь. Бурханы зарлигуудыг сахих нь амлагдсан олон адислалыг авчирдаг. Есүс Христийн бас нэгэн гэрээ болох Мормоны Ном нь зарлигуудыг сахих болон үл сахихаас үүдэлтэй үр дагавруудын тухай өгүүлдэг. Их Эзэн 1 Нифайн 2-р бүлэгт, “Миний зарлигийг дагахын хэрээр та нар дэгжинэ...”⁵ гэж сургасан байдаг.

Энэ амлалтад Мормоны Номын ихэнх бошиглогчид онцгой ач холбогдол өгчдагтан өгүүлсэн байдаг. Мянган жилийн түүх, эдгээр үгсийн үнэнийг гэрчилдэг. Энэхүү захиас өнөөдөр ч бидэнд хамаатай юм. Бид Их Эзэний зарлигийг дагаснаар ухаалаг дүгнэлт хийж сурч, хэрэгжүүлж чадна.

Бид хүнд шийдвэр гаргахдаа дээр удирдамжуудыг баримталбал хэрхэн шүүх ёстойг илүү сайн мэдэх болно гэдгийг би гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, амен.

ЭШЛЭЛ

1. Матай 7:1. Мөн Матай 7:1, Иосеф Смитийн Орчуулгын зүүвэр тайлбарыг үз. Энд Аврагч “шударга бусаар шүүхгүй байхыг” бидэнд зарлиг болгосон байдаг.

2. Лук 10:40--42.

3. Иохан 11:20--27-г үз.

4. Иохан 14:27.

5. 1 Нифай 2:20.